



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 07 сарын 21 өдөр

Дугаар А/237

Мөрөн сум

Барилгын тохижилтын ажлыг хүлээж авах
комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.2, 35.1.6, 48 дугаар зүйлийн 48.1, 48.6, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын төвийн төв замын гудамж талбайн тохижилтын ажлыг хүлээж авах чиг үүрэг бүхий комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:

Б.Энхжаргал (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга)

Гишүүд:

Х.Даваасүрэн (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн, Ерөнхий архитектор)

Ж.Жавзанпагма (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасгийн дарга)

Л.Бямбасүрэн (Онцгой байдлын газрын Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч, хошууч)

Ж.Улаанбаатар ("Хөвсгөл барилга захиалагчийн төв" ОНӨААТҮГ газрын хяналтын инженер)

Зураг төслийн байгууллагын төлөөлөл:

Н.Ууганцэцэг ("Итгэлт чандмань" ХХК-ийн Захирал)

Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл:

Г.Цээпил ("Туурайн тамга" ХХК-ийн Захирал)

Ашиглагч байгууллагын төлөөлөл:

Л.Аззаяа (Бүрэнтогтох сумын Засаг даргын орлогч)

Г.Ундармаа (Бүрэнтогтох сумын Засаг даргын тамгын газрын нягтлан бодогч)

Ч.Эрдэнэчимэг (Бүрэнтогтох сумын Ерөнхий боловсролын сургуулийн Бага сургуулийн менежер)

Комиссын нарийн бичгийн дарга:

Б.Баасанжав (Хөвсгөл аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын мэргэжилтэн)


2. Барилгын ажлыг ашиглалтад оруулах үйл ажиллагааг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулж, комиссын ажлын тайлан, шийдвэрийг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд 2022 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор танилцуулахыг Комиссын дарга (Б.Энхжаргал)-д даалгасугай.

3. Барилгын ажлыг ашиглалтад оруулсантай холбоотой баримт бичгийг бүрдүүлэн аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасаг болон холбогдох байгууллагуудад хүлээлгэн өгөхийг Комиссын нарийн бичгийн дарга (Б.Баасанжав)-д үүрэг болгосугай.

4. Комиссын бүрэлдэхүүн чанаргүй барилгын ажил хүлээн авсан тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгүүлэхийг анхааруулсугай.

5.Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (П.Ариунбат)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН